

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН 2019-2023 ОНЫ СТРАТЕГИ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

№	Хэрэгжүүлэх стратеги	Хэмжих үзүүлэлт	Биелэлт
Стратегийн зорилго 1.			
Эрүүл мэндийн салбарын бодлого, тогтолцооны судалгааг өргөжүүлэн хөгжүүлэх, үндэсний тооцоо, технологийн үнэлгээ, төр хувийн хэвшлийн түншлэлийн бодлого, төслийн хэрэгжилтийг үнэлэх, шийдвэр гаргагчдыг чанартай мэдээ, мэдээллээр хангах			
Зорилт 1.1. Бодлого, шийдвэрийн нотолгоо, мэдээллийн чанарыг сайжруулах			
1	Нийт мэргэжилтэнд эзлэх судлаач мэргэжилтний хувийг нэмэгдүүлэх	<p>Мэргэжилтний 30 хувиас доошгүй нь салбарын хэмжээний судалгааны багт хамтран ажилласан байх</p> <p>Эрдмийн зэрэгтэй ажилтны тоо 2-оос доошгүй нэмэгдсэн байх</p>	<p>Судалгаа, шинжилгээ хийх мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор “Мэргэжилтэн бүр судлаач” уриан дор төвийн мэргэжилтнүүдийн судалгааны ажлыг эмхэтгэл болгон түүвэрлэж “Бүтээлийн товчоо” эмхэтгэлийг жил бүр уламжлал болгон гаргадаг.</p> <p>Бүтээлийн товчоо эмхэтгэлд:</p> <ul style="list-style-type: none"> - 2018 онд – 11 судалгаа - 2019 онд – 15 судалгаа - 2020 онд – 10 судалгаа - 2021 онд – 8 судалгаа - 2022 онд – 9 судалгаа - 2023 онд – 11 судалгаа тус тус эмхэтгэлд нийтлэгдсэн. <p>Мөн төвийн нийт 30 мэргэжилтэнг АШУҮИС-ийн “Судалгааны арга зүйн сургалт”-д 2021, 2022 онуудад хамруулсан.</p> <p>2023 онд “Мэргэжилтэн бүр судлаач” эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулсан.</p> <p>Тус төвд 2018 онд Докторын зэрэгтэй 1 албан хаагч ажиллаж байсан бол 2019, 2022, 2023 онуудад 3 албан хаагч Анагаах ухаан болон Боловсрол судлалаар докторын зэрэг хамгаалж 2023 онд 4 болж 3-аар нэмэгдсэн.</p>

		<p>Дотоодын болон олон улсын сэтгүүлд бүтээлээ хэвлүүлдэг мэргэжилтний тоо жилд 2-оос доошгүй байх</p>	<p><u>Дотоодын сэтгүүл:</u> Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг үнэлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, салбарын хүний нөөцийн төлөвлөлт, эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааны зохион байгуулалтыг боловсронгуй болгох, эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоотой холбоотой нийт 72 бүтээл дотоодын сэтгүүлүүдэд хэвлэгдсэн байна.</p> <p><u>Олон улсын сэтгүүлд:</u></p> <ul style="list-style-type: none"> • Guillon M, Mathonnat J, <u>Narantuya B, Dorjmyagmar B, Enkhtsetseg E.</u> Exploring the efficiency of primary health care provision in rural and sparsely populated areas: a case study from Mongolia. Health Policy Plan. 2022 Aug 3;37(7):822-835. doi: 10.1093/heapol/czac042. PMID: 35670108. • Монгол Улсад бүртгэгдсэн хорт хавдрын эрсдэлт хүчин зүйл, тархвар зүйн судалгааг БНСУ-ын Йонсей их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуульд хэвлүүлсэн. /2021 он/ • Эрүүл мэндийн зардлаас үүдэлтэй санхүүгийн сүйрэлд өртөх нь судалгааг БНСУ-ын Йонсей Их Сургуульд бичиж хамгаалсан. /2023 он/ • Эрхтэн шилжүүлэн суулгалтын 2023 оны сэтгүүлд “Амьгүй донороос эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний өнөөгийн байдал, ирээдүйн чиг хандлага” судалгааг нийтлүүлсэн.
--	--	--	---

			<ul style="list-style-type: none"> • Radnaa Gochoo, Oyuntsetseg Namsrai, Dagvatseren Begzsuren, Bat-Erdene Jargalsaikhan, Enkhsaikhan Lkhagvasuren, Chimedragchaa Chimedtseren. “The Effect of Musk on Neurons in the Pattern of Ischemic Stroke”. Central Asian Journal of Medical Sciences (CAJMS). pISSN2413-8681, eISSN 2414-9772. 2020; 6(2):66-73 • Radnaa Gochoo, Chimedragchaa Chimedtseren, Dagvatseren Begzsuren, Khaliunaa Tumurbaatar, Bat-Erdene Jargalsaikhan, Oyuntsetseg Namsrai. “Effect of Musk deer on serum levels of cytokines in rat”. Journal of Eastern-Western Pharmacology and Pharmacy, pISSN 2521-1609, eISSN 2788-8126. 2021; 4(1):25-29 • Эрхтэн шилжүүлэн суулгалт- Монгол улсад” нэртэй 4 хуудас бүхий өгүүллийг Дэлхийн эрхтэн шилжүүлэн суулгалтын сэтгүүлийн 2022 оны 01 дүгээр сарын 106 дахь дугаарт нийтлүүлсэн. • Increasing the consent for Brain death donor family members (ATWeek 2019) • Expanding Brain death donor transplantation in Mongolia (ATWeek 2019) • Public awareness survey on Organ Donation and Transplantation (ATWeek 2019) • Healthcare staff knowledge and attitude toward organ donation in Mongolia (ATWeek 2019) • Brain death donor determination in Mongolia (ATWeek 2019)
--	--	--	--

			<ul style="list-style-type: none"> • Deceased donor organ Transplantation Development in Mongolia (CAST 2021) • How to improve consent rate organ donation in Hospitals (CAST 2021) • Increasing the consent for brain death donor family members (ATW 2022) • Health Professional Education (ATW 2022) • Organ Donation and Transplantation in Mongolia (Transplant journal)
		<p>Мэргэжилтний 30 хувиас доошгүй нь салбарын хэмжээний болон Олон Улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж оролцсон байх.</p>	<p>Салбарын хэмжээний хурлууд, эрдэм шинжилгээний хурлуудад төвийн албан хаагчид чиг үүргийн дагуу болон судалгааны ажлын хүрээнд илтгэл тавьж хэлэлцүүлдэг. Түүнчлэн олон улсын эрдэм шинжилгээний хурлуудад тавьсан онцлох илтгэлүүдийг дурьдвал:</p> <ul style="list-style-type: none"> - 2019, 2022, 2023 онд “Asian transplantation week”, “Congress of Asian society of transplantation”, “The Transplantation Society” хуралд илтгэл тавьж оролцсон. - Radnaa G, Chimedragchaa Ch,Dagvatseren B, Bat-Erdene J, Oyuntsetseg N. The effect of musk on pathologic model of ischemic stroke. International Symposium of Traditional Medical Integrative Medicine: Development Achievements Trends and Prospects, Mongolian Journal of Integrated Medicine. Sept 23. 2021. Ulaanbaatar Mongolia. 2021; 9(3):220-221 - Radnaa G, Oyuntsetseg N, Bat-Erdene J, Chimedragchaa Ch. “Results of musk effects on ischemic stroke”. 20th WPA World Congress of Psychiatry – 10-13 March 2021. Abstract no:142

			<ul style="list-style-type: none"> - Азийн Эрхтэн шилжүүлэн суулгалтын долоо хоног олон улсын хуралд Тархины үхэлтэй донорын үйл ажиллагааг өргөжүүлэх төслийн хэрэгжилтийн талаар илтгэл тавьж оролцсон – 2020 он - Монгол улсад бүртгэгдсэн хорт хавдрын эрсдэлт хүчин зүйл, тархвар зүйн судалгааг БНСУ-ын Ёнсей их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуульд хэлэлцүүлсэн. - Эрүүл мэндийн зардлаас үүдэлтэй санхүүгийн сүйрэлд өртөх нь судалгааны тайланг БНСУ-ын Ёнсей Их Сургуульд бичиж хамгаалсан.
2	Судалгаанд зориулсан албан ёсны лицензтэй програмуудын хүртээмж, хангамжийг нэмэгдүүлж, судалгааны эх сурвалжуудын хамрах хүрээг өргөжүүлэх	Судалгааны программ хангамж болон эх сурвалжуудыг худалдан авахад ЭМХТ-ийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх эрдэм шинжилгээний зардлын 5 хувиас доошгүйг зарцуулах	<p>Төвийн мэргэжилтнүүд өдөр тутмын үйл ажиллагаа болон судалгаа, эрдэм шинжилгээний ажилд албан ёсны дараах програмуудыг ашиглаж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Эмнэлгийн мэргэжилтнүүдэд нотолгоонд суурилсан орчин үеийн анагаах ухааны ололт, амжилтыг цаг алдалгүй оношилгоо, эмчилгээнд ашиглах боломж олгосон UpToDate цахим платформыг нэвтрүүлсэн. - Эрүүл мэндийн статистикийн нээлттэй өгөгдлийн https://1313.mn - Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тохиолдол, эрсдэлийн бүртгэл eburtgel.hdc.gov.mn, нийт 380 эрүүл мэндийн байгууллагын мэдээлэлд судалгаа, дүн шинжилгээ хийж ажиллаж байна. - Магадлан итгэмжлэлийн программ https://health.acc.hdc.gov.mn/ Магадлан итгэмжлэлийн программ 2022 оны 01 сараас хэрэглээнд нэвтэрч одоогоор

			<p>магадлан итгэмжлэгдсэн 977 эрүүл мэндийн байгууллагын мэдээлэлд судалгаа, дүн шинжилгээ хийж ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын улирал тутмын орлого зарлагын мэдээ, тайланг хүлээн авдаг medee.1212.mn - Жилийн эцсийн тайланг хүлээн авах программ http://maldb.nso.mn/aanb/ - Статистикийн мэдээ, тайлангийн HinfoStata, hinfo.3.0 программ - Эрүүл мэндийн эмнэлгийн тусламжийн өдөр тутмын мэдээний burtgel.mohs.mn программ - sudalгаа.gov.mn программд тус албанаас хийгдсэн судалгааны төслүүдийг оруулдаг ба бусад байгууллагаас хийсэн судалгааг татан уншдаг. <p>Эдгээр программ хангамжуудын санхүүжилтэд төвийн үйл ажиллагааны нийт төсөвийн:</p> <ul style="list-style-type: none"> - 2019 онд 0,16 - 2020 онд 3,17 - 2021 онд 1,64 - 2023 онд 1,8 хувийг зарцуулаад байна.
3	Мэргэжлийн нийгэмлэг, холбоо, байгууллага, эвсэлийн үйл ажиллагааг ЭМХТ-ийн судалгааны үр дүнг нэмэгдүүлэхэд ашиглах	Мэргэжлийн нийгэмлэг, байгууллагатай хамтарч ажиллах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	<ul style="list-style-type: none"> - 2021 онд ЭМЯ, ЭМХЗ-тай хамтран “Коронавируст халдварын тусламж, үйлчилгээний өнөөгийн байдлыг судлан, зураглалыг шинэчлэн боловсруулах” төсөл хэрэгжүүлсэн. - Ферди Францын олон улсын судалгааны байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Өрхийн эрүүл мэндийн төвийн үр ашгийн тооцооллын судалгаа”-ны дата мэдээллийг Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоотой хамтран өрхийн

			<p>эмнэлгүүдээс 2022 онд цуглуулж хамтран ажилласан.</p> <p>2019-2023 онд төгсөлтийн дараах багц цагийн богино хугацааны сургалтыг мэргэжлийн нийгэмлэг, холбоод 68, Эмнэлгийн мэргэжилтний мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааг мэргэжлийн нийгэмлэг, холбоод 31 төрийн бус байгууллагатай тус тус хамтран ажиллаж байна.</p>
4	<p>Байгууллагын захиалгат судалгаа, бодлогын судалгаа, төсөл, хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> • 15 сая төгрөгөөс дээш дүнтэй байгууллагын захиалгат болоод бодлогын судалгааны тоог 2-т хүргэх • Судалгааг дэмжих сан байгуулах 	<p>2019-2023 онд хийгдсэн захиалгат болон бодлогын судалгаанууд:</p> <p>2019 онд</p> <ul style="list-style-type: none"> - ДЭМБ-ын санхүүжилтээр “Монгол улсын 2018 оны нянгийн эсрэг эмийн хэрэглээний судалгаа” - НҮБ-ын ХАС-гийн санхүүжилтээр “Эх, нярайн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэхэд шаардлагатай өртөг тооцох аргачлалыг боловсруулах” <p>2020 онд</p> <ul style="list-style-type: none"> - ДЭМБ-ын санхүүжилтээр “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын заавар боловсруулах” <p>2022 онд</p> <ul style="list-style-type: none"> - ДЭМБ-ын санхүүжилтээр “Хүн амын нас баралтын бүртгэл мэдээллийн чанарыг үнэлэх” - ДЭМБ-ын санхүүжилтээр “Коронавируст халдвар (ковид-19)-ын бүртгэл мэдээлэл, цар тахлын үеийн эрүүл мэндийн статистик мэдээллийн нөхцөл байдал, коронавируст халдвар (зовид-19)-ын шалтгаант нас баралт, бүх шалтгаант нас баралтад дүн шинжилгээ

			<p>хийж илүүдэл нас баралт (Excess mortality), нас баралтын түвшин (CFR)-г тооцоолох ажил”</p> <p>2023 онд</p> <ul style="list-style-type: none"> - ДЭМБ-ын санхүүжилтээр “Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг хүн амын өвчлөл, тоног төхөөрөмжийн хэрэглээтэй уялдуулан судлах нь” - ДЭМБ-ын санхүүжилтээр “ЭМҮТ-ийн эрхзүйн орчныг шинэчлэх” нь сэдэвт судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэсэн.
Зорилт 1.2. Эрүүл мэндийн үндэсний тооцоо, эдийн засгийн дүн шинжилгээг тогтворжуулах			
5	ЭМҮТ-ны асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлэх, мэргэжилтнүүдийн болон ажлын залгамж холбоог алдагдуулахгүй байх зохион байгуулалтын бүтцийн тогтвортой байдлыг хангах	ЭМҮТ-ны асуудал хариуцсан мэргэжилтнүүд бүхий зохион байгуулалтын бүтэц бий болж ажиллагсдын тоо нэмэгдсэн байна.	<p>2018 онд ЭМҮТ-ны асуудал хариуцсан мэргэжилтэн 2 байсныг төвийн захирлын 2022 оны А/42 дугаар тушаалаар 3 болгон нэмэгдүүлсэн.</p> <p>ЭМҮТ-ны асуудал хариуцсан мэргэжилтнүүд бүхий зохион байгуулалтын бүтэц бий болж ажиллагсдын тоо нэмэгдсэн байна. Эрүүл мэндийн эдийн засаг, бодлогын судалгааны албанд</p> <ul style="list-style-type: none"> - ЭМҮТ, эдийн засгийн дүн шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн -1 - ЭМҮТ-ны судалгаа хариуцсан мэргэжилтэн -1 - ЭМҮТ-ны мэдээний сан хариуцсан мэргэжилтэн -1 гэсэн батлагдсан орон тоогоор ажиллаж байна.
6	ЭМҮТ-ны үзүүлэлтүүдийг гаргахад зайлшгүй шаардлагатай судалгаануудын жагсаалтыг гаргаж, тогтмол, тодорхой	Шаардлагатай судалгаанууд тогтмол, тодорхой давтамжтайгаар хийгдэж үр дүнгийн тайлангийн тоо нэмэгдсэн байна.	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн үндэсний тооцооны үзүүлэлтийг эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас боловсруулсан “Эрүүл мэндийн тооцооны систем 2010” аргачлалын

	<p>давтамжтайгаар хийх ажлыг зохион байгуулах</p>		<p>дагуу 3 ангиллаар тооцож, 3 үзүүлэлтийн тооцооллын үр дүнг танилцуулан (2002-2014)-оны ЭМҮТ-ны үзүүлэлтийг 2017 онд гаргасан байсан бол,</p> <ul style="list-style-type: none"> • “Эрүүл мэндийн тооцооны систем 2011” аргачлалаар 7 ангиллаар тооцож, үндсэн 3 үзүүлэлт (1-рт Эрүүл мэндийн зардал, түүний дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь, 2-рт Эрүүл мэндийн зардлын өсөлт, 3-рт Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал)-ийн хүрээнд 2015 оны үр дүнг 2019 онд тооцож гаргасан. • 2022 онд 2016, 2021 оны, 2023 онд, 2017 - 2020 оны тооцооллыг “Эрүүл мэндийн тооцооны систем 2011” аргачлалын дагуу 9 ангиллаар тооцож, тооцооллын үр дүнд үндэслэн үндсэн 31 үзүүлэлтийг тооцож гаргасан. <p>Түүнчлэн Эрүүл мэндийн үндэсний тооцоог тооцоход дараах судалгаануудыг 2 жил тутамд нэг удаа тогтмол хийдэг. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Гадаадад эмчлүүлсэн иргэдийн зардлын судалгаа • Хандивлагч байгууллагуудын зардлын судалгаа • ТББ-ын зардлын судалгаа <p>Бүх шатны эмнэлгүүдийн зардлыг тусламж үйлчилгээний төрлөөр ангилах судалгааг жил бүр тогтмол зохион байгуулж мэдээлэл цуглуулан эрүүл мэндийн үндэсний тооцоонд тусламж үйлчилгээний ангилал тооцоход ашиглаж байна.</p>
7	<p>ЭМҮТ, эдийн засгийн дүн шинжилгээ хариуцсан нэгжийн техникийн</p>	<p>ЭМҮТ-ны асуудал хариуцсан мэргэжилтнүүд орчин үеийн тооцооллын техник хэрэгслээр хангагдаж, чадавхжсан мэргэжилтнүүдийн тоо нэмэгдсэн байна.</p>	<p>Эрүүл мэндийн үндэсний тооцоо хариуцсан мэргэжилтнүүдийг ДЭМБ болон байгууллагын санхүүжилтээр орчин үеийн өндөр хүчин чадал бүхий компьютероор хангасан.</p>

	болон ур чадварыг тогтмол нэмэгдүүлэх		<p>2019 онд БНСУ-ын Сөүл хотноо зохион байгуулагдсан Эрүүл мэндийн үндэсний тооцоог тооцох Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн бодлогын гишүүн орнуудаас зохион байгуулдаг сургалтад ЭМҮТ, эдийн засгийн дүн шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн оролцсон.</p> <p>Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын НАРТ программын сургалтад 2021 онд үндэсний тооцоо хариуцах мэргэжилтнүүд цахимаар хамрагдсан ба тооцоололд НАРТ болон EXCEL программыг ашиглан боловсруулж байна.</p> <p>ДЭМБ-ын зөвлөх Фе Вида Н.Ди-Лиачо 2019 онд ЭМҮТ-ны чиглэлээр үзүүлэх зөвлөх үйлчилгээний болон техник туслалцааны хүрээнд дараах ажлуудыг хийсэн. үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. ЭМҮТ-ны шинэчлэгдсэн системийг ЭМҮТ-ны мэргэжилтнүүд болон холбогдох хүмүүст танилцуулах сургалт хийсэн 2. ЭМҮТ-ны талаар ерөнхий ойлголт, ач холбогдол, үр дүнг бодлого, шийдвэр гаргахад хэрхэн ашиглах талаар шийдвэр гаргагчдад танилцуулсан 3. ЭМҮТ-ны 2015 оны мэдээллийг Stata болон НАРТ програм хангамжийг ашиглан боловсруулахад ЭМҮТ-ны мэргэжилтнүүдийг дадлагажуулсан.
8	Бодлого боловсруулагч болон шийдвэр гаргагчдад ЭМҮТ-ны үр дүнг хэрхэн ашиглах талаар сургалтыг тодорхой давтамжтайгаар зохион байгуулах	Бодлого боловсруулагч болон шийдвэр гаргагчид ЭМҮТ-ны үр дүнг хэрхэн ашиглах талаар мэдлэг, мэдээлэлтэй болсон байна.	<p>Эрүүл мэндийн үндэсний тооцооны үр дүнг тодорхой давтамжтайгаар тайлагнаж байна.</p> <ul style="list-style-type: none"> - 2019 онд 2015 оны үр дүнг танилцуулах үйл ажиллагааг зохион байгуулсан. - 2022 онд 2016 оны Эрүүл мэндийн үндэсний тооцоог НАРТ программаар 9 ангиллаар тооцож гаргасан. 2022.11.18-нд 987 дугаартай албан бичгээр болон PPT

			<p>хэлбэрээр бэлдэж ЭМЯ-нд үр дүнг хүргүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> - 2021 оны оны Эрүүл мэндийн үндэсний тооцооллыг “Эрүүл мэндийн тооцооны систем-2011” стандартын дагуу 9 ангиллаар улсын төсөв, ЭМД, хувийн даатгал, ХХЭМБ, гадаадад эмчлүүлэгчдийн зардал, ТББ болон хандивлагчдын зардлын мэдээлэлд үндэслэн НАРТ программаар боловсруулсан. Үр дүнг ЭМЯ-нд 2022 оны 12 сарын 28-ны өдөр 1144 тоот албан бичгээр хүргүүлсэн. - 2023 онд 2017-2018 оны Эрүүл мэндийн үндэсний тооцооллыг “Эрүүл мэндийн тооцооны систем-2011” стандартын дагуу 9 ангиллаар улсын төсөв, ЭМД, хувийн даатгал, ХХЭМБ, гадаадад эмчлүүлэгчдийн зардал, ТББ болон хандивлагчдын зардлын мэдээлэлд үндэслэн НАРТ программаар боловсруулсан. Үр дүнг ЭМЯ-нд 2023 оны 03 сарын 20-ны өдөр 192 тоот албан бичгээр хүргүүлсэн. - 2023.04.11-ний өдөр ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газартай хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны уулзалтаар Эрүүл мэндийн үндэсний тооцооны ажлын явц үр дүнгийн талаар танилцуулсан. - 2023 оны үзүүлэлт номын танилцуулах уулзалтад “Эрүүл мэндийн эдийн засаг бүлэгт” 2020 он хүртэлх үр дүнг танилцуулсан. - 2019-2020 оны Эрүүл мэндийн үндэсний тооцооллыг “Эрүүл мэндийн тооцооны систем-2011” стандартын дагуу 9 ангиллаар улсын төсөв, ЭМД, хувийн даатгал, ХХЭМБ, гадаадад эмчлүүлэгчдийн зардал, ТББ болон
--	--	--	---

			<p>хандивлагчдын зардлын мэдээлэлд үндэслэн НАРТ программаар боловсруулсан. Үр дүнг ЭМЯ-нд 2023 оны 06 сарын 08-ны өдөр 469 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> - 2023 оны 11 сарын 02-нд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтэн, ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын зөвлөх болон нарт тооцооллын үр дүнг танилцуулсан. - 2016-2021 оны Тооцооллын үр дүнг Удирдлагын зөвлөлийн 2023 оны 11 сарын 13-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн гарсан шийдвэрийн дагуу ЭМЯ-ны “Эрүүл мэндийн үндэсний тооцооны зохицуулах зөвлөл”-д 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 1127 дугаар албан бичгээр хүргүүлсэн. - 2016-2021 оны Тооцооллын үр дүнг тус төвийн “Мэргэжилтэн бүр судлаач” эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлсэн.
9	Мэдээллийн бүхий л эх үүсвэрүүдээс холбогдох мэдээллүүдийг цуглуулж мэдээллийн нэгдсэн сан үүсгэх	ЭМҮТ-ны мэдээллийн сан бүрдсэн байна.	<p>Эрүүл мэндийн үндэсний тооцооны мэдээллийн сан бүрдүүлэх хүрээнд: 2016-2023 оны</p> <ul style="list-style-type: none"> - Бүх шатны улсын эмнэлгүүдийн зардлын мэдээлэл - Хандивлагч байгууллагуудаас хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн мэдээлэл - Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын зардлын мэдээлэл - Гадаадад эмчлүүлсэн иргэдийн зардлын мэдээлэл - Улсын эмнэлгүүдийн зардлын мэдээлэл болон ЭМДС-ийн орлого зарлагын мэдээллийг цуглуулаад байна.

			Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын мэдээлэл цуглуулах хүрээнд улирлын орлого зарлагын мэдээг medee.1212.mn вэб программаар, жилийн эцсийн орлого зарлагын мэдээг ААНБ-2 аппликейшин программаар тус тус цуглуулан тооцоололд ашиглаж байна.
Зорилт 1.3. Эрүүл мэндийн салбарын хөгжил, удирдлага, технологийн ахиц дэвшил, бодлого боловсруулалт, эрүүл мэндийн байгууллагын хөгжлийн олон талт асуудлын хүрээн дэх ЭМХТ-ийн нөлөөллийг нэмэгдүүлэх			
10	Эрүүл мэндийн салбарын хэрэгцээ, шаардлагад үндэслэн тодорхой чиглэлээр бодлогын судалгаа, дүн шинжилгээ хийх	Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, хэрэглэгчдийг баримт, нотолгоогоор хангасан судалгааны тайлангийн тоог өсгөх	<p>СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН ОНЦЛОХ СУДАЛГАА:</p> <p>Нийт 40 орчим судалгааны үр дүнд үндэслэн бодлого шийдвэр гарсан.</p> <ul style="list-style-type: none"> • Бүтээлийн товчоо цувралаар тус төвөөс 2019 онд- 15, 2020 онд 10, 2021 онд 8, 2022 онд 8, 2023 онд 11 судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн байна. • Сумын эрүүл мэндийн төвийн үр ашгийн тооцооллын судалгаа /2020 он/ • Нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, бэлэн байдлыг SARA аргачлалын дагуу үнэлсэн байдал /2020 он/ • Төв эмнэлэг, Төрөлжсөн мэргэшлийн төв, БОЭТ, аймаг, дүүргийн НЭ-үүдийн үр ашгийн судалгаа /2020 он/ • Эрүүл мэндийн байгууллагын амбулаторийн үзлэгийн цаг товлолт, хүлээгдлийн судалгаа /2021 он/ • Хүний нөөцийн байршил хэрэгцээ, хүрэлцээний судалгаа /2021 он/

			<ul style="list-style-type: none"> • Хавдрын тусламж үйлчилгээний чиглэлээр хувь хүний халааснаас гарах албан ба албан бус төлбөрийн судалгаа /2021 он/ • Эрүүл мэндийн байгууллагуудын урт хугацааны тусламж үйлчилгээ, эмнэлгийн орны ашиглалтын нөхцөл байдлын дүн шинжилгээ /2022 он/ • Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үр ашгийн тооцооллын судалгаа /2022 он/ • Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийг хүн амын өвчлөл, тоног төхөөрөмжийн байдалтай уялдуулсан судалгаа /2023 он/ • “Монголд тохиолдож буй зонхилон тохиолдох хавдруудын эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний шинэ технологийн үнэлгээ, судалгаа”-2022 • 2021 онд ДЭМБ-ын санхүүжилтээр ЭМТҮЧАБА-ны албаны ажилтнуудын судалгааг хийж ЭМЯ-нд хүргүүлсэн. • 2023 онд ДЭМБ-ын санхүүжилтээр Магадлан итгэмжлэлийн өнөөгийн байдлын дүн шинжилгээ, Эрүүл мэндийн магадлан итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлэх замын зураглал /2024-2028/ 2 судалгааг Магадлан итгэмжлэлийн зөвлөлд танилцуулсан. 	
11	Эрүүл салбарын ажилтны шаардлагад	мэндийн удирдах хэрэгцээ, нийцсэн	Сургалтын хэрэгцээ тодорхой болсон байна.	2021 онд Төрийн сангийн санхүүжилтээр зохион байгуулах эрүүл мэндийн удирдах ажилтны сургалтын эрэлт, хэрэгцээг тодорхойлох зорилгоор “Эрүүл мэндийн удирдах ажилтны

	<p>сургалтын тогтолцоог бэхжүүлэн, тогтворжуулах</p>		<p>сургалтын эрэлт, хэрэгцээ тогтоох судалгаа” хийсэн бөгөөд судалгаанд эрүүл мэндийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагын /сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төв/ 71, аймаг, нийслэл, дүүргийн 2-р шатлалын эрүүл мэндийн байгууллагын 222, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн 264, нийт 557 эрүүл мэндийн удирдах албан тушаалтан хамрагдсан Уг судалгаагаар Сүүлийн 5 жилд манай улсад хийгдсэн эрүүл мэндийн удирдах ажилтны сургалтын эрэлт, хэрэгцээг тодорхойлох судалгаатай танилцан, хамрагдсан удирдах ажилтнуудаас асуумж аван дараагийн жилүүдэд Удирдах ажилтнуудад шаардлагатай сургалтын хэрэгцээг тодорхойлсон.</p> <p>Түүнчлэн Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сангаас 2021 онд ЭМЯ-ны харьяа байгууллагын 259, аймгийн ЭМГ-ын харьяа байгууллагын 192, НЭМГ-ын харьяа байгууллагын 172, бусад яамны харьяа 73 буюу 696 удирдах ажилтны мэдээллийг шүүж, мэдээний санг үүсгэж, нас хүйс, боловсрол, мэргэжил, мэргэшил зэрэг 35 үзүүлэлтээр дүн шинжилгээ хийж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.</p>
		<p>Сургалтын журамд өөрчлөлт оруулж батлуулсан байна Удирдах ажилтны сургалтын тогтолцоог бүрдүүлэх.</p>	<p>ЭМС-ын 2021 оны А/445 дугаар “Төгсөлтийн дараах үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” тушаалаар “Эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалт” S(s)09190004 индекс бүхий төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл нэмэгдэж удирдах ажилтны сургалтын тогтолцоо бүрдсэн.</p>
		<p>Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх</p>	<p>1. “Эрүүл мэндийн удирдлага зохион байгуулалт” төрөлжсөн мэргэшлийн</p>

			<p>сургалтад 2021-2023 онд нийт 7 эмнэлгийн мэргэжилтэн суралцаж, эрүүл мэндийн удирдлага зохион байгуулалтын менежерээр бэлтгэгдсэн.</p> <p>2. ЭМЯ, ЗГХА-Удирдлагын академитэй хамтран удирдах ажилтны сургалтыг 2022 онд 2 удаа зохион байгуулж, ЭМЯ-ны харьяа байгууллагын 101, БОЭТ, аймгийн нэгдсэн эмнэлгийн 75 буюу нийт 176 удирдах ажилтанг хамруулж, мэдлэг мэргэжлээ дээшлүүлэн чадавхижсан.</p> <p>3. Төвийн захирлын 2023 оны А/116 тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу эрүүл мэндийн 160 гаруй удирдах ажилтанг сургалтад хамруулсан.</p> <p>4. 2022 онд БНТУ-н Acibadem групп эмнэлгийн их сургуульд Удирдлага зохион байгуулалт, эмнэлгийн менежментийн сургалтад удирдах ажилтнуудыг хамруулсан.</p> <p>5. ЭМС-ын 2023 оны А/422 дугаар тушаалаар Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтны чадавхийг бэхжүүлэх зорилгоор БНСУ-д 40 удирдах ажилтанг байгууллагын хөгжил, алсын хараа, менежмент, эрүүл мэндийн даатгал, санхүүгийн тогтолцоо, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, ёс зүй, манлайлал судвээр мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан.</p>
12	Эрүүл мэндийн салбарын төр хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд үнэлгээ хийх аргачлал батлуулан, үнэлгээ хийх	Үнэлгээ хийх батлагдсан аргачлал, Үнэлгээний тайлан, танилцуулсан байдал, гарсан шийдвэр	Аймаг нийслэл, ЭМЯ-ны харьяа үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаас үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 12 дугаар сарын 26 өдрийн А/156 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу орлого

			<p>зарлагын тайлан мэдээг medee.1212.mn программаар улирал тутамд цуглуулдаг. Мөн тус төв нь аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, ЭМЯ-ны харьяа хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын статистикийн мэдээ, тайланг сар, улирал, жилийн эцсийн байдлаар Hinfo.3.0, HinfoStata программаар авч байна</p>
<p>Стратегийн зорилго 2. Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээлэл, зайн анагаах ухаан, цахим эрүүл мэнд, мэдээллийн технологийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулж олон улсын болон бүсийн жишигт нийцүүлэх</p>			
<p>Зорилт 2.1. Мэдээллийн технологи, мэдээллийн удирдлагын бодлогын хэрэгжилтийг сайжруулах</p>			
13	Эрүүл мэндийн мэдээллийн олон улсын стандартыг нэвтрүүлэх	Олон улсын HL7 стандартыг Монгол улсад нэвтрүүлсэн байна.	<p>Олон улсын Fhir стандартыг “Цахим эрүүл мэнд” төсөлтэй хамтран Монгол хэл дээр хөрвүүлж http://fhir.mn/ цахим хуудсанд Монгол, Англи хэлбэрээр байршуулсан.</p> <p>Тус стандартыг баримтлан HIEP мэдээлэл солилцооны платформ хөгжүүлэгдэж мэдээллийг солилцож эхэлсэн бөгөөд E-Hospital программ хангамжийг Fhir стандартын дагуу хөгжүүлэн анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад 2022 онд ашиглуулсан.</p>
<p>Зорилт 2.2. Эрүүл мэндийн статистик мэдээллийн төрөл, агуулгыг боловсронгуй болгож чанарыг сайжруулах</p>			
14	Үндэсний түвшинд тооцох эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийн тодорхойлолт, тооцох аргачлалыг олон улсын аргачлалд нийцүүлэн үе шаттайгаар шинэчлэн олон улсын болон бүсийн жишигт нийцүүлэн боловсруулах	Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлалыг шинэчлэн батлуулсан байна.	<p>Үндэсний түвшинд тооцох эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийн тодорхойлолт, тооцох аргачлалыг олон улсын аргачлалд нийцүүлэн Үндэсний статистикийн хорооны даргын 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн “Эрүүл мэндийн салбарын статистик үзүүлэлтийг тооцох аргачлалыг батлах тухай” А/220 дугаар тушаалаар батлагдсан. Нийт 105 үзүүлэлтийг тооцон гаргаж байна.</p>

15	<p>Эрүүл мэндийн статистик үзүүлэлтийн эмхэтгэлүүдийг олон улсын түвшинд нийцүүлэн боловсруулж гаргах</p>	<p>Эрүүл мэндийн сар, улирал, жилийн статистикийн үзүүлэлтүүдийн эмхэтгэлийн агуулга шинэчлэгдэж олон улсын түвшинд хүрсэн байна.</p>	<p>Тогтвортой хөгжлийн зорилт, Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтын үзүүлэлт, нөхөн үржихүй, эх, хүүхдийн эрүүл мэнд, өсвөр насны эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг сүүлийн 10 жилээр баяжуулсан, мөн хүн амын нас баралт, өвчлөлийн мэдээллийг дэлгэрүүлэн тооцоолон харуулдаг болсон.</p> <p>Мөн 2020 онд Эрүүл мэндийн салбар үүсч хөгжсөний 100 жилийн ой тохиосон бөгөөд тухайн жилийн эмхэтгэлд зарим боломжит үзүүлэлтүүдийг эрүүл мэндийн салбарын тоон мэдээллийг бүртгэж эхэлсэн үеэс харьцуулан тооцоолж оруулснаараа онцлог болсон.</p> <p>“Эрүүл мэндийн үзүүлэлт” 2022 эмхэтгэлд Алсын хараа 2050 урт хугацааны баримт бичгийн эрүүл мэндийн үзүүлэлтийн биелэлтүүдийн шалгуур үзүүлэлтийг биелэлтийг сүүлийн 10 жилийн байдлаар тооцоолон гаргаж, хүрэх түвшинтэй нь харьцуулан дүн шинжилгээ хийж оруулсан.</p> <p>Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийг олон улсынхтай харьцуулан шинээр гарах боломжтой үзүүлэлтийг судлан, тодорхойлох, үзүүлэлтийн жагсаалт, мэдээллийн эх үүсвэр, давтамж зэрэг мэдээллийг бий болгох зорилгоор Орчны эрүүл мэндтэй холбоотой үзүүлэлтүүдийг судлан тошоцоолж эхлээд байна.</p> <p>2023 оны эмхэтгэлд шинээр орчны эрүүл мэндтэй холбоотой 2 шалгуур үзүүлэлтийг тооцоолон 10 000 хүн харьцуулан боловсруулж оруулсан.</p>
----	---	---	--

16	Эрүүл мэдээний тайлангийн өөрчлөлт, нийцүүлэн шинэчлэх	мэндийн бүртгэл, маягтыг хөгжилтэй тогтмол	Эрүүл мэндийн мэдээний бүртгэлийн маягтыг ҮСХ-ны арга зүйн байнгын зөвлөлөөр батлуулж, хэрэгжүүлж эхэлсэн байна.	Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журам, бүртгэлийн маягтыг шинэчлэн батлах тухай” А/611 дүгээр тушаалаар нийт 11 хавсралт бүхий журам батлагдсан. Нийт 145 заалт бүхий журмын хэрэгжилтийн өнөөгийн байдлыг 2023 онд үнэлсэн. Үнэлгээгээр бүртгэлийн маягтууд болон асуумжууд давхардал ихтэй, эмнэлгийн шатлал тус бүрт нэг ижил хэдий ч онцлогт нь тохирсон асуумжуудыг оруулж өгсөн тул 1 бүртгэлийн маягт анхан шат болон лавлагаа шатлалд тус тус давхар дугаарлагдаж бүртгэгддэг болох нь харагдсан. Иймд бүртгэлийн маягтуудыг цахим хэлбэрт оруулах шаардлагын хүрээнд шинэчлэн боловсруулж, маягтын тоог 50 хувь бууруулах тооцоолол гарган шинээр боловсруулан батлуулахаар ажиллаж байна.
			Батлагдсан маягтыг ном болгон хэвлүүлэх, түгээн тарааж нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан байна.	Батлагдсан маягтуудыг төвийн цахим хуудсанд Цахим ном хэлбэрээр байршуулан татаж авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. http://www.hdc.gov.mn/post/643/
17	Health-Info программ хангамжийн шинэчилсэн хувилбарыг боловсруулах	программ	Статистикийн модулийг хөгжүүлэн олон улсын түвшинд хүргэх	2021 онд Health-Info 3.0 программ хангамжийн веб хувилбарыг хөгжүүлэн хэрэглээнд нэвтрүүлсэн. Веб хувилбарт бүртгэлийн 23 маягт, 4 бүлэг тайлангийн маягт орж бусад эрүүл мэндийн системтэй лавлагаа мэдээлэл болон бүртгэлийн маягтын мэдээллийг сервис байдлаар солилцож эхэлсэн. Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 тушаалын дагуу бүртгэл тайлангийн маягтын дагуу өөрчлөлт шинэчлэлтийг хийсэн. Программ хангамжийн сервер нь Үндэсний дата төвд байршиж кибер аюулгүй байдал, системийн тасралтгүй ажиллаагааг хангаж

			байгаа бөгөөд И-Монгол, Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системүүдтэй мэдээлэл солилцож байна. 2023 онд Эрүүл мэндийн яамны техникийн хорооноос гаргасан шийдвэрийн дагуу “Эрүүл мэндийн ахнах шатны тусламж үйлчилгээнд ашиглагддаг VHS програм хангамж”-ийг эрүүл мэндийн статистик мэдээллийн H-info3.0-оос салгаж сервер, датабааз, системийн хувьд бие даасан систем болгон хөгжүүлж байна. Хөгжүүлэлтийг “Креддо terra” ХХК-тай хамтран гүйцэтгэж байна.
18	Health-Info программ хангамжийг бүх шатны төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлэх	Программыг нэвтрүүлэх төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэх	Health-Info 3.0 программ хангамжийг төрийн болон хувийн хэвшлийн бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд ашиглаж эрүүл мэндийн статистик мэдээллийг бүртгэж, тайлан мэдээллийг боловсруулдаг. 2018 онд 1198 байгууллагын 6169 хэрэглэгч тус программ хангамжийг ашиглаж байсан бол 2023 онд 1403 байгууллагын 8041 хэрэглэгч өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Үүнээс хэвийн хэвшлийн байгууллага 700, төрийн байгууллага 703 тус тус байна.
19	Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээллийн цахим хуудас ажиллуулах	Хүн амын эрүүл мэндийн мэдээ мэдээллийг олон нийт мэдээлэл хэрэглэгчдэд хүргэх цахим хуудсыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх	Эрүүл мэндийн мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор www.1313.mn цахим хуудсыг 2023 оноос ажилуулж эхлээд байна. Эрүүл мэндийн статистик мэдээллийн цахим хуудаст Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын гүйцэтгэлд үйлчлүүлэгчийн хөндлөнгийн үнэлгээ хийх боломжийг бүрдүүлэн мэдээллийг ил тод байршуулсан. Өгөгдлийн санд 10 бүлгийн танилцуулга, хүснэгт, тайлан цэсийг үүсгэсэн. Нас баралтын 2014-2022 оны мэдээллийг насны бүлэг, хүйс, эрүүл мэндийн байгууллагын шатлал, эрүүл мэндийн байгууллага, өвчний

			олон улсын ангиллын нэршил, код, аймаг, хот, сум, дүүргээр оруулан хэрэглэгчид эксел файлаар татан авах боломжтойгоор мэдээллийг байршуулсан. Өвчлөлийн 2014-2022 оны мэдээллийг аймаг, хот, насны бүлэг, хүйсээр оруулан татан авах боломжтой байдлаар байршуулсан.
20	Цахим шалгалтын үйл ажиллагааг өргөжүүлэх	Цахим шалгалтын техник, тоног төхөөрөмжийн тоо, хүчин чадал, шалгалтанд хамрагдагсдын тоо нэмэгдсэн байна.	2014 оноос танхимаар цахим хэлбэрээр шалгалт зохион байгуулан авч байсан бол 2021 оноос Цахим шалгалтын программыг шинэчлэн “Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн сан”-гийн программ хангамжийг ашиглан шалгалт авч эхэлсэн. Ингэснээр эрүүл мэндийн ажилчид орон зайнаас үл хамааран гар компьютерт, гар утаснаасаа цахимаар шалгалт өгөх, шалгалтын дүнгээ харах боломжтой болсон. Цахим шалгалтын системийн аюулгүй байдал, тасралтгүй ажиллагааг хангахаар Үндэсний дата төвд байршуулан ажиллаж байна. 2018 онд цахим шалгалтад 198 хүн хамрагдаж байсан бол 2023 онд 13900 хүн хамрагдаж цахим шалгалт өгсөн хүний тоо 70 дахин өссөн.
Зорилт 2.3. Телемедицин, цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологийг ашиглан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах үйл ажиллагааг өргөжүүлэх, зайн сургалтыг өргөжүүлэх			
21	Эрүүл мэндийн байгууллагуудыг телемедицин үндэсний сүлжээнд холбох	Идэвхитэй ба идэвхигүй телемедицин сүлжээнд бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудыг холбох	Телемедицин тусламж үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай судалгааг 2023 онд нийт 387 эрүүл мэндийн байгууллагаас цахим /google form/-аар авсан. Тус судалгааны дүгнэлтээр: <ol style="list-style-type: none"> 1. Эрх зүйн орчныг сайжруулах 2. Нэгдсэн программ хангамжтай болох 3. Хүний нөөцийн бэлэн байдлыг хангах зэрэг асуудлууд тулгарсан. Эрх зүйн орчныг сайжруулахаар Телемедицин үйлчилгээний журмыг

			шинэчлэх ажлын хэсгийг ЭМЯ дээр байгууллан ажиллаж байна. Программ хангамжийн ажлын даалгаврыг боловсруулан эрүүл мэндийн төрөлжсөн мэдээллийн сантай холбох ажлыг эхлүүлж байна.
22	Дүрс дамжуулах, хадгалах PACS системийг нэвтрүүлэх	II болон III шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад PACS системийг нэвтрүүлэх	Дүрс дамжуулах, хадгалах PACS системийг ЭМЯ, Дэлхийн банкны дэмжлэгтэй “Цахим эрүүл мэнд” төсөлтэй хамтран 2 болон 3 дугаар шатлалын 6 эмнэлэгт 2020 он 5 сарын 21-ний өдрөөс нэвтрүүлэн ашиглаж эхэлсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Улсын нэгдүгээр төв эмнэлэг - Улсын гуравдугаар төв эмнэлэг - Гэмтэл согог судлалын үндэсний төв - Увс аймгийн нэгдсэн эмнэлэг - Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлэг - Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг тус тус ашиглаж байна.
23	Эрүүл мэндийн ажилтны зайн сургалтыг өргөжүүлэх	Эрүүл мэндийн ажилтнуудыг ажлын байран дээр чадавхижуулах зайн сургалтын төв байгуулах	2018 оныг хүртэл зайн сургалтыг телемедициний тоног төхөөрөмжийг ашиглан зохион байгуулдаг байсан бол 2019 оноос Zoom болон Google meet программыг ашиглан цахим сургалтыг хийж эхэлсэн. 2021 онд зайн сургалтын платформ /surgalt.hdc.gov.mn/-г хөгжүүлэн тасралтгүй суралцах зайн сургалтыг зохион байгуулж эхэлсэн. 2023 оны байдлаар тус системд 13 бүлгийн 52 цахим сургалт байршиж 2672 хэрэглэгч тогтмол ашиглаж байна. Тус программыг Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэл мэдээллийн сантай сургалтын мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлснээр хэрэглэгчид цахим сургалтын программыг ашиглан орон зай цаг хугацаанаас үл хамааран мэдлэг ур чадвараа дээшлүүлэн багц цагийн сургалтын гэрчилгээг авах боломж бүрдсэн.

Зорилт 2.4. Эрүүл мэндийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, эрүүл мэндийн үзүүлэлтийн цаашдын чиг хандлагыг тодорхойлох чадавхийг бэхжүүлэх			
24	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын мэдээллийн мэргэжилтнийг чадавхижуулах, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах	Эрүүл мэндийн статистикч их, бага эмч нар болон мэдээллийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах	Бүртгэл мэдээллийн ажилтны мэргэжил олгох болон дээшлүүлэх сургалтыг 2000 оноос эхлэн жилд 2 удаа зохион байгуулж, дунджаар 25-30 хүнийг хамруулан зохион байгуулж мэргэшсэн бүртгэл мэдээллийн ажилтныг бэлтгэн гаргасан.
		Өвчний олон улсын X ангилал, үйлдлийн олон улсын IX ангиллын сургалтыг тогтмол зохион байгуулах	Өвчний олон улсын 10-р ангилал, ICD-10 өвчнийг кодлох, шивэлтийг хэрхэн хийх, хэрхэн кодлох талаар өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудын статистик бүртгэл мэдээллийн мэргэжилтэн болон зарим эмч нарт сургалтыг зохион байгуулж жилдээ дунджаар 300 хүнийг хамруулж байна.
25	Эрүүл мэндийн мэдээллийн технологи, телемедициний мэргэжилтнүүдийн ур чадварыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтын хэрэгцээг тооцон танхимын болон зайн сургалтыг зохион байгуулах	Эрүүл мэндийн мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах, мэдлэг ур чадварыг нэмэгжүүлэх зорилгоор танхимын болон зайн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж 2019-2023 онд нийт давхардсан тоогоор 335 мэдээллийн технологийн мэргэжилтэнг хамруулсан. Сургалтын агуулга: <ol style="list-style-type: none"> 1. Active directory & Domain controller 2. Web application development 3. Сүлжээний зохион байгуулалт 4. Сүлжээний төхөөрөмжийн тохиргоо 5. Техникийн даалгавар болосвруулах ур чадварыг эзэмшүүлэх 6. Телемедициний үйлчилгээний холболт 7. Дэлгэцийн зохиомжийг боловсруулах HTML, Bootstrap, CSS
Стратегийн зорилго 4.			
Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих, төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох;			
Зорилт 4.1. Зайн сургалтыг алслагдсан орон нутгийн эмч, мэргэжилтний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд өргөнөөр ашиглах			
26	Эмч, эмнэлгийн ажилтнуудад зориулсан		ДЭМБ, АХБ-ны дэмжлэгтэйгээр www.surgalt.hdc.gov.mn цахим сургалтын

	зайн сургалтын нэгдсэн платформыг бий болгож, үйл ажиллагаанд нэвтрүүлэх	Зайн сургалтын нэгдсэн платформ үйл ажиллагаанд нэвтэрсэн байна.	платформыг хөгжүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр нийт 25 модул бүхий 103 видео хичээлийг байршуулж 2724 хэрэглэгч бүртгүүлж ашигласан. Энэхүү платформыг 2023 онд Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан /hr.hdc.gov.mn/-тай холбох хөгжүүлэлтийг хийж, дээрх программд бүртгэлтэй эрүүл мэндийн салбарын 62000 гаруй эмнэлгийн мэргэжилтэн ашиглах боломж бүрдсэн.
27	Салбарын хүний нөөцийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх, тогтвортой үйл ажиллагааг хангах	<ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагааны шаардлага хэрэгцээнд бүрэн нийцсэн салбарын хүний нөөцийн хөгжил, мэдээллийн нэгдсэн сантай болсон байна. • Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санг хөтлөх, мэдээллийг шинэчлэх, ашиглах журмыг боловсруулан Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна. 	<p>Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан /hr.hdc.gov.mn/ программыг шинээр боловсруулж, 2022 оны 04 дүгээр сараас зөвшөөрөл, сургалт, мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн.</p> <p>Тус программ нь 10 модулийн хүрээнд эрүүл мэндийн ажилтны мэдээллээр цахим сан үүсгэж 62000 гаруй эрүүл мэндийн ажилтан бүртгэгдсэн байна.</p> <p>Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сангийн үйл ажиллагаанд зөвшөөрлийн болон мэргэшлийн зэргийн гэрчилгээг цахимжуулах, шалгалтын төлбөр, тэмдэгтийн хураамжийг программаар төлөх зэрэг хөгжүүлэлтийг хийж, төгсөлтийн дараах сургалт, мэргэшлийн зэрэг, зөвшөөрөл олгох үйл ажиллагаа программаар явагдаж, цаг хугацаа, зардал хэмнэсэн давуу талтай болсон.</p>
Зорилт 4.2. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын зохион байгуулалтыг сайжруулах			
28	Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах	<ul style="list-style-type: none"> • Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын мэргэшүүлэх болон тасралтгүй сургалтын 	1. “Резидент эмчийн ажиллах үлгэрчилсэн журам”-ын боловсруулж Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/226 дугаар тушаалаар батлагдсан.

<p>сургалтын эрх зүйн орчинг өөрчлөх</p>	<p>зохицуулалттай холбоотой журмыг шинэчлэн батлуулсан байна.</p> <ul style="list-style-type: none"> • Төгсөлтийн дараахь сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх журам, зардлын жишиг, сургалтын тэтгэлэг олгох шалгуур, тэтгэлгийн хэмжээ, зардлын жишгийг өөрчлөн боловсруулж Сангийн болон Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлуулсан байна. 	<ol style="list-style-type: none"> 2. Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагад зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журамд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/450 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон. 3. “Эмнэлгийн мэргэжилтний ажиллан суралцах журам”-ын төслийг боловсруулж, ЭМС-ын 2020 оны А/484 дүгээр тушаалаар батлагдсан. 4. “Резидент эмчийн албан тушаалын тодорхойлолт, Хөдөлмөрийн гэрээний үлгэрчилсэн загварыг боловсруулж, ЭМС-ын 2021 оны А/20 дугаар тушаалаар батлагдсан. 5. ЭМС-ын 2019 оны А/337 тушаалаар батлагдсан “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”-ыг шинэчлэх зорилгоор төвийн захирлын 2021 оны А/154 тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж хэрэглэгчдээс санал авч, хэлэлцүүлэг хийж гарсан саналыг нэгтгэж ажилласан. ЭМС-ын 2022 оны А/135 тушаалаар батлагдсан ажлын хэсэгт ажиллаж, журмын хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээг ажлын хэсэгт танилцуулсан. 6. ЭМСС, СС-ын 2015 оны 97/56 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх журам, сургалтын зардлын жишиг,
--	---	--

			<p>мэргэжлийн зэргийн шалгалтын багц, төлбөрийн хэмжээг батлах тухай” журмыг шинэчлэх саналыг ЭМЯ-д төвийн 2021 оны 86 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>ЭМС-ын 2022 оны А/135, А/169 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллан ЭМЯ-ны БТГ, ТЗУГ-тай хамтран вакуум хэлэлцүүллийг зохион байгуулж, журмын шинэчилсэн төслийг боловсруулж, хэрэглэгчдийн дунд үе шаттай хэлэлцүүлэг хийж, ЭМЯ-ны цахим хуудсаар санал авахад хамтран ажилласан.</p> <p>Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын 2022 оны А/26 дугаар тушаалаар "Эмнэлгийн мэргэжилтний багц цагийн богино хугацааны сургалт зохион байгуулах журам"-ыг баталж, үйл ажиллагаандаа мөрдөж байна.</p>
29	Эмнэлгийн мэргэжилтний мэргэшүүлэх болон давтан сургалтын цөм хөтөлбөр, төлөвлөгөөг үнэлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх	Жилд 3-аас доошгүй сургалтын цөм хөтөлбөр, төлөвлөгөөг үнэлж, шинэчилсэн байна.	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/774 тушаалаар үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх ажлын хэсэг байгуулагдан зохион байгуулалтаар хангаж, хөтөлбөрийг боловсруулан, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 2022 онд 34, 2023 онд 3 нийт 37 жишиг хөтөлбөрийг батлуулсан. • Төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг шинээр болон шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн их эмчийн 6, сувилагч тусгай мэргэжилтний 7 буюу нийт 13 хөтөлбөрийг батлуулсан.

			<ul style="list-style-type: none"> Мэргэжил дээшлүүлэх сургалтын 6 хөтөлбөрийг шинээр боловсруулан ЭМХТ-ийн захирлаар батлуулсан.
30	Сургалт эрхлэгч байгууллагын үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг өөрчлөх	Сургалт эрхлэгч байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж батлуулсан байна.	ЭМХТ-ийн захирлын 2019 оны А/32 тушаалаар эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллагын явцын үнэлгээний 6 бүлэг, 22 дэд, 64 нарийвчилсан шалгуур үзүүлэлт, тайлангийн загварыг баталж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.
31	Аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэгт үндсэн мэргэшлийн сургалт явуулах орчин нөхцлийн бүрдүүлэх	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн эмч нарыг эмнэл зүйн сургагч багшийн сургалтанд хамруулах	Эмнэлзүйн сургагч багш бэлтгэх сургалтад 2019-2023 онд нийт 789 их эмч, 271 сувилагч, 94 эх баригчийг хамруулсан. Үүнээс аймаг дүүргийн нэгдсэн эмнэлгийн 231 их эмч, 84 сувилагч, 63 эх баригч буюу нийт 378 эмч, эмнэлгийн мэргэжилтний Эмнэл зүйн сургагч багшаар бэлтгэсэн байна.
		Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, ОУБ-тай хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, эмч мэргэжилтнийг чадавхижуулсан байна.	Япон улсын Жайка ОУБ-ын дэмжлэгээр 2015-2020, 2021-2024 онуудад хэрэгжүүлж буй төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төслийн хүрээнд 2019-2023 онд Япон улсад зохион байгуулагдсан 6 удаагийн сургалтад 21 их эмч, 15 сувилагч, 18 эх баригч хамрагдсан. Сургалтад хамрагдсан нийт 54 мэргэжилтнээс аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгээс их эмч 8, сувилагч 7, эх баригч 7 буюу нийт 22 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна.
32	Төгсөлтийн дараах сургалтад хамрагдагсдын (дотоод, гадаад) мэдлэг, ур чадварыг сорих онол практикийн бага хурал зохион байгуулах үйл ажиллагааг	<ul style="list-style-type: none"> ТДС-д суралцагчдын дунд эрдэм шинжилгээ, судалгааны онол практикийн бага хурлыг жилд 1 удаа зохион байгуулдаг болсон байна. Мэдлэг, ур чадварын уралдаан, тэмцээнийг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулдаг болсон байна. 	Эх барих эмэгтэйчүүд судлалын үндсэн мэргэшлийн сургалтад суралцаж буй резидент эмч нарын дунд “Бүтээлч Идэвхтэй дайчин авхаалжит сэргэлэнчүүдийн тэмцээн”-ийг Өргөө АГТМЭ-тэй хамтран 2023 онд зохион байгуулж, сургалт эрхлэх 5 байгууллагын суралцагчдыг хамруулсан.

	боловсронгуй болгон, тогтмолжуулах		
33	Ерөнхий мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх	Хөтөлбөр батлагдаж, сургалт эхэлсэн байна.	ЭМХЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн 2018 оны 01 тогтоолоор “Ерөнхий мэргэшил судлал” үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг батлуулж Орхон аймгийн БОЭТ, Чингэлтэй дүүргийн ЭМТ-д сургалтыг эхлүүлсэн. Сургалтыг өргөжүүлэх ажлыг зохион байгуулж 2021 онд 3, 2022 онд 3, 2023 онд 7 байгууллага нэмэгдсэн.
34	Эмнэл зүйн сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, эмнэлзүйн сургагч багшийг үе шаттайгаар бэлтгэх	Эмнэлзүйн сургагч багш бэлтгэх төлөвлөгөө батлагдаж, сургалтыг зохион байгуулж эхэлсэн байна.	Эмнэлзүйн сургагч багш бэлтгэх сургалт Японы ОУ-ын хамтын ажиллагааны Жайка байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Анхан болон хоёр дахь шатлалын мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах” төслийн хүрээнд боловсруулсан хөтөлбөрийн дагуу 2016 оноос эхлэн зохион байгуулагдсан бөгөөд 2019-2023 онд Эмнэл зүйн сургагч багш бэлтгэх сургалтад 789 их эмч, 271 сувилагч, 94 эх баригчийг хамруулсан. Сургалтын хөтөлбөрийн агуулгыг олон улсад нэвтэрч буй шинэ аргачлалтай уялдуулан шинэчлэх зорилгоор “Чиглүүлэгч багш нарын чадавхижуулах сургалт”-ыг 2023 онд зохион байгуулсан. Сургалтаар чиглүүлэгч багш нарын төлөөлөл 18 эмч, сувилагч, эх баригчид сургалтын хөтөлбөрийн агуулгын хүрээнд Competencies, EPAs /Entrustable Professional Activities/ чадамж, үр дүнгийн шинэ аргачлалыг сургалтын зорилго, стратеги, үнэлгээний хичээлийн сэдэвтэй хэрхэн уялдуулан тусгах талаар суралцаж, нэгдсэн ойлголттой болсон бөгөөд хөтөлбөрийн шинэчлэл хийгдэж байна.
Зорилт 4.3. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл сунгах үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, хүчин чадлыг нэмэгдүүлж, боловсронгуй болгох			

35	Дотоод, гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, нөхөн олгох асуудлын эрх зүйн орчинг өөрчлөх	<ul style="list-style-type: none"> • Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмын төслийг боловсруулж Эрүүл мэндийн сайдаар батлуулсан байна. ▪ Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам, гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний загвар, холбогдох маягтыг өөрчлөн боловсруулж батлуулсан байна. ▪ Эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбоотой зардлын жишгийг өөрчлөн боловсруулж Сангийн болон Эрүүл мэндийн сайдаар батлуулсан байна. 	<ul style="list-style-type: none"> ▪ Эрүүл мэндийн сайдын 2023 оны 08 дугаар сарын 14-ны “Журам шинэчлэн батлах тухай” А/295 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар “Зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах, багц цаг тооцох, зөвшөөрлийн гэрчилгээ олгох, нөхөн олгох”, 2 дугаар хавсралтаар “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх журам”-ыг шинэчлэн баталсан. ▪ Дээрх тушаалын 4 дүгээр хавсралтаар Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчигээний загварыг шинэчлэн баталсан.
36	Эмнэлгийн мэргэжилтний (дотоод, гадаад, орон нутаг) мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт авах үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх	<ul style="list-style-type: none"> • Гадаадын эмнэлгийн мэргэжилтнээс мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт авах сорилын цахим сантай болсон байна. • Гадаадын эмнэлгийн мэргэжилтнээс мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтыг 2019 оноос цахимаар авдаг болсон байна. 	Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/295 дугаар тушаалын “Зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах, багц цаг тооцох, зөвшөөрлийн гэрчилгээ олгох, нөхөн олгох” журмын 3.1-д заасны дагуу эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн сан hr.hdc.gov.mn программаар дотоодын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, зөвшөөрлийн хүсэлт, олголт цахим хэлбэрт бүрэн шилжээд байна.

			2021 он - 5884, 2022 он - 5642, 2023 он-13900 эмнэлгийн мэргэжилтэн цахим шалгалтад хамрагдаад байна. Гадаадын эмнэлгийн мэргэжилтний Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтын сорил бүхий цахим сан үүссэн.
37	Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн цахим шалгалтын салбар төвийг орон нутагт байгуулах	Аймаг, орон нутгийн ЗДТГ, ЭМГ, БОЭТ-тэй хамтран бүсийн төвүүдэд цахим шалгалтын салбар төвийг байгуулсан байна.	Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн цахим шалгалтыг эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн сан hr.hdc.gov.mn программаар зохион байгуулдаг болсон ба энэ үйл ажиллагаа 100% цахимжиж шалгалтад орох хүсэлттэй мэргэжилтнүүд зөвшөөрлийн шалгалтыг байгаа газраасаа өгөх боломж бүрдсэн. Мөн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хүсэлт олголт цахимаар олгогддог болсон тул орон нутагт цахим шалгалтын төвүүд байгуулах шаардлага гараагүй.
38	Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн шалгалт авах сорилын (гадаад, дотоод) чанарт шинэчлэл хийх	<ul style="list-style-type: none"> ▪ Шалгалтын сорилын чанарт үнэлгээ хийх, ▪ Сорилын чанарыг олон улсын түвшинд хүргэхэд сорил боловсруулах багийг чадавхижуулах ▪ Сорилын баяжилтыг тогтмол хийх ▪ Гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн шалгалтын сорилын сан үүсгэх, баяжилтыг хангах 	2020-2022 онд 22 чиглэлээр нийт 11 мянган сорил хянагдсан. Мэргэжлийн 24 чиглэлийн 12000 гаруй сорилд ЭМЯ-ны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлтэй хамтран үнэлгээ хийсэн. ЭМХТ-ийн захирлаар батлуулсан удирдамжийн дагуу төрөлжсөн мэргэжлийн 22 сургалт эрхлэх байгууллагыг арга зүйгээр ханган 10 чиглэлийн шинэчлэн баяжуулсан 4000 сорилыг шалгалтын сорилын цахим санд оруулсан.
Зорилт 4.4. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлого, нийгмийн баталгааг сайжруулах Чиглэлээр шинэчлэл хийх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх			

39	<p>Эмнэлгийн мэргэжилтний ажлын ачаалал, норм нормативийг тогтоох чиглэлээр судалгаа хийж санал боловсруулах</p>	<ul style="list-style-type: none"> • ЭМЯ, ХЯ, МЭМАҮЭХ зэрэг байгууллагатай хамтран эрүүл мэндийн ажилтны ажлын ачааллын судалгаа хийсэн байна. ▪ Эмч, эмнэлгийн мэргэжилтний хөдөлмөрийн норм, нормативын талаар санал боловсруулж холбогдох дээд байгууллагад хүргүүлсэн байна. 	<p>Эрүүл мэндийн салбарын болон эрүүл мэндийн ажилтны ажлын ачааллын холбоотой дараах судалгаануудыг хийж гүйцэтгэлээ.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эрүүл мэндийн байгууллагын орны тоог тасаг, эмнэлгийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан төлөвлөх нь судалгаа-2019 ▪ Сумын эрүүл мэндийн төвийн үр ашгийн тооцоо 2017 ба 2018 он - 2020 ▪ Эмч, эмнэлгийн мэргэжилтний хүний нөөцийн байршил, хэрэгцээний судалгаа – 2021 ▪ Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын /ЭМТҮЧАБ/ албаны орон тооны гишүүдийн судалгаа -2021 ▪ Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний үндэсний тооцооны түлхүүр 78 үзүүлэлтийг гаргахад шаардлагатай мэдээллийн бэлэн байдлын үнэлгээний тайлан - 2021 ▪ “Сумын эрүүл мэндийн төвийн үр ашгийг тооцох” судалгааны тайлан - 2021 ▪ Эмнэлгүүдийн ор ашиглалтад сүүлийн 10 жилийн байдлаар, улсын болон аймаг, нийслэлийн түвшинд хийсэн дүн шинжилгээ – 2022 ▪ Өндөр өртөгтэй оношилгооны тоног төхөөрөмжийн ашиглалт, хэрэглээг хүний нөөцийн хангамжтай уялдуулан судалсан байдал – 2022 ▪ Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй нь харьцуулан судлах нь 2023
----	--	--	---

		Эрүүл мэндийн салбарын ажилтан, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлуулсан байна.	Эрүүл мэндийн тухай хуулийн 47 дахь заалтын /Хөдөлмөрийн гэрээг 2021.01.01-нээс мөрдөж ажиллах/ хэрэгжилтийг хангах зорилгоор “Резидент эмчийн албан тушаалын тодорхойлолт, Хөдөлмөрийн гэрээний үлгэрчилсэн загварыг боловсруулж, ЭМС-ын 2021 оны А/20 дугаар тушаалаар батлагдаж, резидент эмчийн ажлын байр, эрх үүргийг тодорхойлж, цалинтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн.
Стратегийн зорилго 5.			
Тусламж, үйлчилгээний чанарын тасралтгүй хөгжлийг дэмжин, чанар, аюулгүй байдал, магадлан итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлэх			
Зорилт 5.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар-аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалтыг олон улсын жишигт нийцүүлж сайжруулах			
40	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар-аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар-аюулгүй байдлын чиглэлээр хэрэгжиж буй тушаал, дүрэм, журам шинэчлэгдсэн байна.	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар-аюулгүй байдлын чиглэлээр дараах тушаалууд шинэчлэгдэн батлагдсан. <ol style="list-style-type: none"> 1. Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/565 дугаар тушаалаар Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны бүтэц, дүрэм 2. Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/566 дугаар тушаалаар “Тусламж, үйлчилгээтэй холбоотой эрсдэлийг бүртгэх, хариу арга хэмжээ авах заавар” 3. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/136 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлын удирдамж, хэрэгжүүлэх төлөвлөгөө” 4. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/352 тушаалаар “Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах журам”

			5. Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/220дугаар тушаалаар “Үйлчлүүлэгчийг аюулгүй тээвэрлэх журам” тус тус батлагдсан.
		ЭМБ нь ажилтны гүйцэтгэлийн үнэлгээнд ЧАБ-н шалгууруудыг тооцдог болсон байна.	Эрүүл мэндийн байгууллага нь ажилтны гүйцэтгэлийн үнэлгээнд чанар аюулгүй байдлын шалгуурыг тооцох талаар дараах байдлаар тусгагдсан. Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/565 дугаар тушаалаар батлагдсан Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны чиг үүргийн 3.12-д чанар сайжруулах арга хэмжээний ололтыг тэмдэглэж, урамшуулан ажиллах, 3.16-д чанарын шалгуурт дүн шинжилгээ хийн, хяналт үнэлгээг тогтмол хийх талаар туссан байна.
		ЭМЯ, ЭМГ, байгууллагын Эрсдэлийн хорооны бүтэц, чиг үүргийн тухай ЭМС-ын тушаалаар үлгэрчилсэн журам гарч ЭМБ хэрэгжүүлж эхэлсэн байна.	Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/566 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын 4.1.2-д Эрүүл мэндийн байгууллага нь эрсдэлийн удирдлагын багтай байх талаар заасан ба 4.2.2-д Эрүүл мэндийн байгууллагын удирдлага нь эрсдэлийн удирдлагын талаар үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар тусгасан болно. Мөн тушаалаар тусламж, үйлчилгээтэй холбоотой эрсдэлийг бүртгэх, хариу арга хэмжээ авах зааврыг баталсан.
41	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар-аюулгүй байдлын мэдээ, мэдээллийн бүртгэл, хэрэглээг сайжруулах	Эрсдэлийн үнэлгээ хийх загвар аргачлалыг шинэчлэн боловсруулснаар эрүүл мэндийн байгууллагууд загвар аргачлалын дагуу эрсдэлийн үнэлгээг хийдэг болсон байна.	Эрүүл мэндийн байгууллагууд Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/566 дугаар тушаалаар батлагдсан тусламж, үйлчилгээтэй холбоотой эрсдэлийг бүртгэх, хариу арга хэмжээ авах зааврын дагуу эрсдэлийг бүртгэж, үнэлж байна.

		<p>Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн стандарт үлгэрчилсэн асуумж боловсрогдсон байна.</p>	<p>Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг стандарт үлгэрчилсэн асуумжийн дагуу авсан. 2021 онд батлагдсан Эрүүл мэндийн сайдын А/578 дугаар тушаалаар батлагдсан нэгдсэн асуумжийн дагуу хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээг зохион байгуулсан. 2022 оноос эхлэн ЭМХТ-өөс салбарын хэрэглэгчийн үнэлгээг зохион байгуулах хүрээнд амбулаториор үйлчлүүлэгчийн 18 асуумж, хэвтэн эмчлүүлэгчийн 22 асуумжийг боловсруулж, ЭМЯ, эрүүл мэндийн байгууллагуудаас санал авч, хянан засварлаж, үнэлгээнд ашиглаж байна. Хэрэглэгчийн үнэлгээний нэгдсэн асуумжийг Эрүүл мэндийн статистик мэдээллийн 1313.mn сайтад байршуулсан.</p>
		<p>Эрүүл мэндийн байгууллагуудын сайн туршлага, алдаа зөрчлийн мэдээллийг цуглуулах цахим сантай болсон байна Эрүүл мэндийн байгууллагуудад бүртгэгдсэн алдаа зөрчлийн мэдээнд дүн шинжилгээ хийн, мэдээний чанар, сайжирсан байна.</p>	<p>2022 оны 1 сараас эхлэн “Бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-г ажиллуулж байна. Уг санд тусламж, үйлчилгээтэй холбоотой тохиодол, эрсдэл болон эрүүл мэндийн байгууллагын сайн туршлагыг бүртгэдэг. “Бүртгэл мэдээллийн нэгдсэн санд 2022 оны 1 сараас 2023 оны жилийн эцэс хүртэлх хугацаанд нийт 28 сайн туршлагыг цахим санд байршуулжээ. Тусламж, үйлчилгээтэй холбоотой бүртгэгдсэн тохиолдол, эрсдэлд дүн шинжилгээ хийн, хагас, бүтэн жилээр тайланг ЭМЯ-нд хүргүүлж байна.</p>
		<p>Алдаа зөрчлийн мэдээг бүртгэх, дүгнэлт хийж, эргэн мэдээлэх журам шинэчлэгдсэн байна.</p>	<p>ЭМСайдын 2019 оны А/566 дугаар тушаалаар Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах журмыг баталсан.</p>

42	Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх	ЭМБ-ууд ноцтой тохиолдлуудад RCA шинжилгээг 100% хийж хэвшсэн байна.	Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/566 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 2.3-д Эрүүл мэндийн байгууллагууд ноцтой тохиолдолд үндсэн шалтгааны дүн шинжилгээ хийхээр тусгагдсан. Эрүүл мэндийн байгууллагын ЭМТҮЧАБ Алба нь тусламж, үйлчилгээтэй холбоотой тохиолдлуудад үндсэн шалтгааны дүн шинжилгээ хийх ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.
		ЧАБ-н үндэсний сургагч багш нар бэлтгэгдсэн байна	<ul style="list-style-type: none"> • 2022 онд Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын үндэсний сургагч багшийг бэлтгэх 4 өдрийн сургалтыг зохион байгуулж 35 сургагч багш бэлтгэгдсэн. • 2023 онд сургагч багш нарын мэдлэг бататгах сургалтыг 1 удаа зохион байгуулсан.

		Тусламж, үйлчилгээний чанарын удирдлагыг сайжруулах сургалт зохион байгуулах ЭМЯ-ЭТГ, Чанарын албаны гишүүдийн мэдлэг, ур чадвар сайжирсан байна.	Тусламж үйлчилгээний чанарын удирдлагыг сайжруулах сургалт зохион байгуулах ажлын хүрээнд дараах сургалтууд зохион байгуулагдсан. <ul style="list-style-type: none"> Тусламж, үйлчилгээний чанарын удирдлагыг сайжруулах хүрээнд 2022 онд нийт 8 удаагын сургалтаар 400 гаруй, 2023 онд 10 удаагын сургалтаар 600 гаруй эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх цахим болон танхимын сургалтыг тус тус зохион байгуулсан байна. 2022-2023 онд “Чанар аюулгүй байдлын менежер”-ийн төрөлжсөн мэрэгжлийн 6 сарын сургалтын хөтөлбөрийг батлуулж, 4 байгууллагад сургалт явуулах эрх олгон нийтдээ 4 удаагын сургалтанд 45 хүн хамрагдсан.
Зорилт 5.2. Эрүүл мэндийн байгууллагуудад магадлан итгэмжлэл олгох үйл ажиллагааг боловсронгуй болгох			
43	Эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох эрх зүйн орчныг шинэчлэх	Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журмыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, журамд өөрчлөлт орсон байна.	ДЭМБ-ын санхүүжилтээр “Магадлан итгэмжлэлийн өнөөгийн байдлын дүн шинжилгээ”, “Эрүүл мэндийн магадлан итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлэх замын зураглал /2024-2028/” гэсэн 2 судалгааг 2023 онд хийж Магадлан итгэмжлэлийн зөвлөлд танилцуулсан. 2017 оны Эрүүл мэндийн сайдын А/503 дугаар “Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журам”-ыг шинэчлэх ажлын хэсэг 2023 онд байгуулагдан олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөхөөр ажиллаж байна.

		<p>Магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулсан байна.</p>	<p>JCI олон улсын магадлан итгэмжлэл авсан “Интермед” эмнэлгийн туршлага болон “JCI: Survey Process Guide for Hospitals” гарын авлага, “Accreditation Standarts for Hospitals” стандартуудыг судалсны үндсэн дээр доорхи шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн батлуулсан.</p> <ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/554 дугаар “Эрүүл мэндийн байгууллагыг магадлан шинжлэх шалгуур батлах тухай тушаал” • Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/179 дугаар “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийг магадлан шинжлэх шалгуур үзүүлэлтийг батлах тухай” • Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/180 дугаар “Сувилал, сэргээн засах, сувилахуйн төвийг магадлан шинжлэх шалгуур үзүүлэлтийг батлах тухай”
		<p>Магадлан итгэмжлэх шинжээч сонгон шалгаруулах, ажлуулах журамд өөрчлөлт орсон байна.</p>	<p>Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/118 тоот “Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шинжээч сонгон шалгаруулах, ажиллуулах журам тушаал”-ыг шинэчлэн Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/412 тушаалаар батлагдсан. Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/158 дугаар тушаалаар 48 магадлан итгэмжлэлийн шинжээч шинээр томилогдсон.</p>

		Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагад явцын ХШҮ хийх журам, шалгуур үзүүлэлт шинэчлэгдсэн байна	Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны А/363 дугаар тушаалаар батлагдсан “Үнэлгээний хуудас, аргачлал батлах тухай” тушаал”-ыг шинэчлэн боловсруулж Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/412 дугаар тушаалаар “Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам” батлагдсан. 2023 оны 12 сараас эхлэн шинэчлэгдсэн журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан.
44	Бүх түвшний эрүүл мэндийн байгууллагууд, магадлан итгэмжлэлийн үндэсний шинжээчдийн чадамжийг дээшлүүлэх	Магадлан итгэмжлэлийн өмнөх болон дараах сургалтыг бүх түвшний эрүүл мэндийн байгууллагуудад зохион байгуулж, ЭМБ чадавхижсан байна.	2019-2023 онуудад: <ul style="list-style-type: none"> • Магадлан итгэмжлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд хүсэлт гаргасан 125 Эрүүл мэндийн байгууллагуудад ажлын байранд зөвлөгөө, мэргэжил арга зүйн зөвлөгөө, ажлын байрны сургалт зохион байгуулан ажилласан. • Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажлын хүрээнд болон магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагад зориулсан сургалтын цахим болон танхмаар зохион байгуулан ажилласан. 15 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1737 эрүүл мэндийн байгууллага хамрагдсан байна.
		Магадлан итгэмжлэлийн шинжээчдэд зориулсан сургалтыг зохион байгуулан, шинжээчдийн мэдлэг, ур чадвар сайжирсан байна.	Шинжээч чадавхижуулах 10 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт давхардсан тоогоор 744 шинжээч хамрагдсан байна.

		Эрүүл мэндийн байгууллага, магадлан итгэмжлэлийн шинжээчид арга зүйн гарын авлагаар хангагдсан байна	2023 онд Магадлан итгэмжлэлийн шинжээчид зориулсан гарын авлага боловсруулан 130 ширхэгийг хэвлүүлэн шинжээчид хүргүүлсэн.
Стратегийн зорилго 7.			
Эс, эд, эрхтний донорын үйл ажиллагааг өргөжүүлэх, нэгдсэн зохицуулалтыг бэхжүүлэх			
Зорилт 7.1. Эс, эд, эрхтний донор, шилжүүлэн суулгах үйл ажиллагааг оновчтой болгох			
45	Эс, эд, эрхтний донор, шилжүүлэн суулгах үйл ажиллагааг оновчтой болгох эрх зүйн орчинг бий болгох	Донорын тухай хуулийг дагаж гарах журмуудыг боловсруулж батлуулах	Донорын тухай хуулийг дагаж гарах 8 журмыг боловсруулан батлуулсан. Үүнд: <ol style="list-style-type: none"> 1. 2018 онд “Донор бэлгийн эс ашиглах, үр хөврөл шилжүүлэн суулгах, Тээгч эхэд үзүүлэх тусламж, үйлчилгээний журам” А/500 дугаар тушаалаар, 2. “Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаатай холбоотой нэгдсэн бүртгэл мэдээллийн сан ажиллуулах журам” А/501 дүгээр тушаалаар, 3. “Донорын зөвшөөрлийн тэмдэглэгээ хийх журам” А/502 дугаар тушаалаар, 4. “Нүдний донор эд авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах, устгах, импортлох журам” А/503 дугаар тушаалаар, 5. “Донороос эс, эд, эрхтэн авах, шинжлэх, боловсруулах, хадгалах тээвэрлэх, устгах журам” А/504 дүгээр тушаалаар, 6. “Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба болон мэргэжлийн багуудын ажиллах журам” А/505 дугаар тушаалаар, 7. 2019 онд “Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах журам” А/164 дүгээр тушаалаар, 8. 2023 онд “Донороос эс, эд, эрхтэн авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах, устгах журам” А/198 дүгээр тушаалаар тус тус батлагдсан.

		Шилжүүлэн суулгах заавруудыг боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангах	<ul style="list-style-type: none"> • Элэг, нойр булчирхай шилжүүлэн суулгах заавруудыг боловсруулан 2018 онд А/19 дүгээр тушаалаар “Элэг шилжүүлэн суулгах эмчилгээний заавар”, • 2020 онд А/128 дугаар тушаалаар “Хүүхдэд элэг шилжүүлэн суулгах эмчилгээний заавар”, • Мөн 2020 онд А/353 дугаар тушаалаар “Нойр булчирхай шилжүүлэн суулгах эмнэл зүйн заавар” тус тус батлагдсан.
		Эрүүл мэндийн байгууллагуудтай гурвалсан гэрээ байгуулах ажлыг эхлүүлэх, үр дүнг тооцох	<ul style="list-style-type: none"> - 2019 онд 4 - 2022 онд 7 ЭМБ-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан. 2022 онд 4 ЭМБ-тай хамтран ажиллах гэрээ дүгнэн ЭМЯ-нд хүргүүлсэн.
Зорилт 7.2. Амьгүй донор тодорхойлох үйл явцыг нэмэгдүүлэх			
46	Амьгүй донор тодорхойлох багийг чадавхжуулах, сургалт зохион байгуулах	Тархины үхлийн оношлогоо эмчилгээний менежментийн сургалтыг зохион байгуулах	Тархины үхлийн оношилгоо эмчилгээний менежмент сэдэвт сургалтыг 2019-2023 онд 5 удаагийн сургалтаар 2000 гаруй эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан.
		Эмнэлгийн мэргэжилтнийг олон улсын богино хугацааны сургалтад хамруулах	УНТЭ, ХСҮТ, УГТЭ, ГССҮТ, ЭХЭМҮТ-ийн эд, эрхтэн шилжүүлэн суулгах багийн 93 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг олон улсын богино хугацааны сургалтад хамруулсан. Үүнд: 2018 онд БНТУ-28, БНСУ-2, Испани улсад-1, 2019 онд БНТУ-10, БНСУ-20, 2021 онд БНТУ-10, 2022 онд БНТУ-12, Аргентин улсад-2, 2023 онд БНТУ-6, БНСУ-1, АНУ-1 эмнэлгийн мэргэжилтнийг тус тус хамруулсан.
		Эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай оношлогоо, эмчилгээний техник хэрэгслээр хангах ажилд дэмжлэг үзүүлэх	2023 онд ДЭМБ-ийн дэмжлэгтэйгээр тархины үхэл оношлоход шаардлагатай доплерографи, электроэнцефалографийн аппарат авч боломжит донор оношлоход ашиглаж байна.
Зорилт 7.3. Нэгдсэн бүртгэл мэдээллийн санг бий болгох			

47	Нэгдсэн бүртгэл мэдээллийн сан бий болгох, олон улсын сүлжээнд нэгдэх	Хүлээх жагсаалт, донор, шилжүүлэн суулгах үйл ажиллагааны нэгдсэн бүртгэл мэдээллийн сангийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх	Нэгдсэн бүртгэл мэдээллийн санг шинээр хөгжүүлэх чиглэлээр төсөл боловсруулан жил бүрийн төсвийн төсөлд, 2022 онд НҮБ-ын Хүүхдийн санд хүргүүлсэн. 2022 онд “Аксис” ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд тус программ хөгжүүлэлтийг хийхээр хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.
		Холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг албан ёсоор авах	ЭМХТ-д МТА байгуулагдсантай холбоотой холбогдох зөвшөөрлийг авахаар ажиллаж байна.
		Олон улсын сүлжээнд нэгдэх хүсэлтийг хүргүүлэх	2020 онд Олон улсын эрхтэн шилжүүлэн суулгах мэдээллийн сантай холбоотой “ASTREG” сүлжээнд нэгдэх хүсэлт гарган, зөвшөөрөл авч Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлсэн. ҮАБЗ “ASTREG” сүлжээнд нэгдэхээс татгалзсан.
Зорилт 7.4. Донорын талаарх мэдээлэл сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх			
48	Донорын тухай мэдээлэл сургалт, сурталчилгааг үе шаттайгаар зохион байгуулах	Олон нийтэд донорын үйл хэргийг таниулах, сурталчлах цахим хуудсыг ажиллуулах	2019 онд Олон нийтэд донорын үйл хэргийг таниулах, сурталчлах зорилготой албаны цахим хуудас www.otcdonor.mn -ыг хөтлөн ажиллуулж байна. 2019-2023 оны хугацаанд жилд дунджаар 2000 гаруй иргэд мэдээлэл авсан байна.
		Иргэдэд зориулсан өдөрлөгийг жилд 1-ээс доошгүй удаа тогтмол зохион байгуулах	Иргэдэд зориулсан “Амьдрал бэлэглэе” өдөрлөгийг 2019, 2022, 2023 онуудад зохион байгуулсан. Үүнд: 2019 онд 1000, 2022 онд 50, 2023 онд 70 гаруй иргэд оролцсон.
		Донорын зөвшөөрлийн маягтыг хэрэглэж эхлүүлэх	Донорын зөвшөөрлийн маягт, донорын картыг хэвлүүлэн иргэдэд түгээн ажиллаж байна. 2019-2023 оны хугацаанд 96 иргэд донорын зөвшөөрлийн маягтад гарын үсэг зурж баталгаажуулан, донорын карт авсан байна.
Зорилт 7.5. Мэдээ, тайланг олон улсын стандартын дагуу тайлагнах, судалгаа шинжилгээ хийх			

49	Мэдээ тайланг олон улсын стандартын дагуу тайлагнах асуумж бий болгох, судалгаа шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлэх	ДЭМБ-ын стандартын дагуу мэдээ тайланг гаргах асуумж боловсруулах	2018-2023 оны хугацаанд ДЭМБ-ын Эрхтэн шилжүүлэн суулгах холбоо (GODT)-руу жил бүр өмнөх жилийн тайланг боловсруулан, нэгтгэж цахимаар хүргэсэн.
		Дотоод гадаадын эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавих	2019-2023 оны хугацаанд дотоод, гадаадын эрдэм шинжилгээний хуралд оролцож, илтгэл тавьсан. Үүнд: Олон улсын хуралд: <ul style="list-style-type: none"> • 2019 онд – 2 (БНСУ-д ATWeek 2019), • 2022 онд – 1 (Аргентин улсад TTS 2022), • 2023 онд 3 (БНСУ-д ATWeek 2023, Хонконг улсад CAST 2023, АНУ-д ISODP) удаа, Дотоодын эрдэм шинжилгээний хуралд: <ul style="list-style-type: none"> • 2019 онд “Эрхтэн шилжүүлэн суулгах монголын холбооны семинар”-т 2 илтгэл, • 2021 онд “ICOT2021” хуралд - 1, • онд “МКОТ2023” хуралд 2 илтгэл тус тус тавьсан.
		Шилжүүлэн суулгах төвтэй хамтран судалгааны ажлыг эхлүүлэх	2019 оноос УНТЭ, ХСҮТ-ийн эд, эрхтэн шилжүүлэн суулгах багтай хамтран “Амьгүй донороос элэг, бөөр шилжүүлэн суулгасан үр дүн” сэдэвт судалгааг хийж байна.
Зорилт 7.6. Хамтын ажиллагааг өргөжүүлэх			
50	Гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах	Гадаадын ижил төстэй байгууллагуудтай холбоо тогтоох, хамтын ажиллагааг эхлүүлэх	2019 оноос эхлэн БНСУ-ын KODA, KONOS, KOTRY, БНТУ-ын ITN, олон улсын “The Transplantation Society”, “Asian Society of Transplantation” байгууллагуудтай хамтыг ажиллагааг эхлүүлэн ажиллаж байна.
		Олон улсын нийгэмлэг, холбоонд гишүүнчлэлээр элсэх	2019 онд олон улсын The Transplantation Society, Asian Society of Transplantation байгууллагын гишүүнчлэлээр элссэн.

		Сургалт, семинар, хурал, уулзалтыг хамтран зохион байгуулах	Дээрх байгууллагуудтай хамтран 2018-2023 оны хугацаанд гадаад улсад 93 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургалт, семинарт хамруулсан.
		Харилцан туршлага судлах	<ul style="list-style-type: none"> • 2019 онд ЭЭШСЦААЗА-ны 3 мэргэжилтэн БНСУ-ын KODA, KONOS, • 2023 онд АНУ-ын OPTN байгууллагуудтай уулзан туршлага судалсан.
Стратегийн зорилго 8.			
Байгууллагын бие даасан, тогтвортой байдлыг хангах			
Зорилт 8.1. Байгууллагын бие даасан, тогтвортой байдал, бүтцийг боловсронгуй болгох			
51	ЭМХТ-ийн бүтэц зохион байгуулалт, ажил үүргийн хуваарийг оновчтой болгох	Зохион байгуулалтын шинэ бүтэц ба ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтуудыг шинэчлэн батлах	<p>2018 оноос хойш 2021 онд Эрүүл мэндийн сайдын “Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай” А/26 дугаар тушаалаар тус төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, чиг үүрэг шинэчлэн батлагдсан.</p> <p>Мөн 2023 онд Эрүүл мэндийн сайдын “Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” А/123 дугаар тушаалаар тус төвийн Магадлан итгэмжлэлийн албанд эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг нэмж баталсан.</p> <p>Энэ дагуу 2021 онд төвийн захирлын “Төвийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагааны стратеги, ажлын байрны үндсэн чиг үүргийг батлах тухай” А/11, 2022 онд “Нэгжийн чиг үүрэг орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” А/42 дугаар тушаалыг тус тус баталж хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>Батлагдсан чиг үүргийн хүрээнд албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг тухай бүр шинэчилсэн.</p>

56	Хүний нөөцийн сургалтын болон нийгмийн баталгааг хангах бодлого, хөтөлбөрийг шинэчлэх	Холбогдох бодлого, хөтөлбөрийг гаргах	“Эрүүл мэндийн хөгжлийн төвийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг шинээр боловсруулан төвийн захирлын 2021 оны А/117 дугаар тушаалаар батлагдсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд жил бүр нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааны болон албан хаагчдыг чадавхжуулах сургалтын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж ЭМЯ-нд жил бүр тайлагнадаг.
		Хамтын гэрээ, дотоод журмыг шинэчлэх	ЭМХТ-ийн Ажил олгогч, ажилтны төлөөлөлтэй хийх “Хамтын гэрээ” 2016-2021 онд байгуулагдсан байсан бөгөөд уг гэрээг хуулийн хугацаанд буюу 2022 оны 5 дугаар сарын 25-нд шинэчлэн байгуулсан. Хөдөлмөрийн тухай шинэчилсэн хуультай нийцүүлэн 17 зүйл бүхий “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг боловсруулан батлуулж, мөрдөн ажиллаж байна. “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн төвийн захирлын 2022 оны А/103 дугаар тушаалаар баталсан.
		Ажлын гүйцэтгэлийн үнэлгээг оновчтой болгох Үйл ажиллагааны үр дүн, чанарт тохирсон урамшууллын тогтолцоог нэвтрүүлэх	Төвийн захирлын 2023 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/99 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын 5 дугаар зүйлд зааснаар албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн зорилтын биелэлт, үр дүнг харгалзан улирал бүр мөнгөн урамшуулах олгох, жилийн эцэст шилдэг

			<p>тэргүүний албан хаагчдыг шагнаж урамшуулах үйл ажиллагааг зохион байгуулдаг. ХДЖ-ийн 11.12-д зааснаар ажлын гүйцэтгэл хангалттай үнэлэгдсэн, идэвх санаачлагатай, сахилга хариуцлагын зөрчилгүй албан хаагчдыг шагнах, урамшуулах, олон жил салбартаа үр бүтээлтэй ажилласан албан хаагчдыг төр засгийн шагналд тодорхойлох ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлж ажилладаг.</p>
		<p>Ажилтан, албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийж, судалгаанд тулгуурласан арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх</p>	<p>Жил бүр албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааг авдаг. Судалгааны асуумжаар ирүүлсэн саналыг Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах болон Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлдэг.</p>
<p>Зорилт 8.2. Байгууллагын үйл ажиллагааг цахим системд нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх</p>			
57	<p>Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг цахим системд нэвтрүүлэх</p>	<p>Архив, албан хэрэг хөтлөлтийн программыг шинэчлэх ERP системтэй болох</p>	<p>Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд 2015 оноос одоог хүртэл байгууллагын дотоод удирдлагын цогц систем www.intranet.gov.mn цахим программыг ашиглаж байгаа бөгөөд 2022 оноос Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем болох www.Erp.e-mongolia.mn -ыг давхар хэрэглээнд нэвтрүүлээд байна.</p> <p>Ингэснээр:</p> <ul style="list-style-type: none"> - Албан хаагчдын үндсэн мэдээлэл - Ажилтны цаг бүртгэл - Албан хэрэг хөтлөлт - Үүрэг даалгавар - Хүний нөөцийн тайлан - Өргөдөл, гомдлын тайлан - Өдөр тутмын ажлын гүйцэтгэлийн мэдээлэл тус тус цахимжаад байна.

		ЭМХТ-ийн архивын баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлэх	Эдгээр программууд дээр байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу цахим архив үүсч Үндэсний дата төв дээр байрших сервер дээр хадгалагдаж байна.
58	Архивын өрөө тасалгааг өргөжүүлэх, зориулалтын шүүгээгээр хангах	ЭМХТ-ийн архивын өрөө, зориулалтын шүүгээний тоог нэмэгдүүлэх	Тус төвийн архив нь 1996 онд албан ёсоор байгуулагдан 28 жил болж байгаа бөгөөд 59, 12, 20м.кв талбай бүхий 3 өрөөтэй. 2023 оны байдлаар 21565 хадгаламжийн нэгж болон 2728 цахим баримт хадгалагдаж байна. Архивын өрөөнүүдэд 2019, 2020 онд тус бүр 6 тавиур бүхий 12 нягтаршуулсан шүүгээ болон 2020 онд цахим баримт хадгалах зориулалтын сефийг тус тус шинээр авч зориулалтын шүүгээний тоог нэмэгдүүлсэн.
59	Дотуур байранд орох хүсэлт болон сонголтыг цахим системд нэвтрүүлэх	Байранд орох өргөдлийг цахимаар бүртгэдэг болсон байна. Байранд орох эмнэлгийн мэргэжилтнийг цахимаар сонгодог болсон байна.	Төвийн цахим хуудсанд байршуулсан холбоосоор Дотуур байранд орох өргөдлийг 2022 онд цахимаар хүлээн авч бүртгэсэн ба 189 хүн бүртгүүлж 150 хүнийг байраар хангасан.
		Программ хангамжийг бий болгон ашиглалтад оруулах	Вэб-д суурилсан Цахим бүртгэлийн программ хангамжийг боловсруулсан боловч 2022 оны 10 дугаар сард Хот байгуулалтын хөгжлийн газраас ЭМХТ-ийн 2-р байрыг газар хөтлөлтөд тэсвэргүй, нурах аюултай гэсэн дүгнэлтийг ирүүлсэн тул дотуур байранд орох хүсэлт авахгүй байгаагаас үүдэн уг программ хангамжийг туршиж эхлээгүй.
Зорилт 8.3. Орон нутгийн эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах сургалтад суралцах хугацаанд амьдрах дотуур байрны орчин, хангамж, үйлчилгээ, хүртээмжийг сайжруулах			
63	ЭМХТ-ийн 2-р байранд урсгал засвар хийх /цахилгааны монтаж, сантехник, барилгын дотоод, гадна засвар/	<ul style="list-style-type: none"> Урсгал засварын төсвийг жил бүрийн улсын төсөвт батлуулах Засварын ажлуудыг цаг хугацаанд нь хийж дотуур байрны амьдрах орчинг сайжруулах 	Жил бүр дотуур байрны урсгал засварын төсвийг улсын төсөвт тусган, засвар үйлчилгээг тогтмол хийж ирсэн. Эдгээр санхүүжилтүүд: - 2019 онд 25 933 450 - 2020 онд 13 393 468

			<ul style="list-style-type: none"> - 2021 онд Ковидын улмаас хийгдээгүй. - 2022 онд 3 725 000 - 2023 онд 23 632 900 төгрөг байна.
65	Эмнэлгийн мэргэжилтний хөгжил, мэдээлэл, сургалт, үйлдвэрлэл, ШУ, эрдэм шинжилгээ, судалгаа, техник, технологийн ордон барих асуудал	<ul style="list-style-type: none"> • Улсын төсөвт энэхүү ордон барих зураг төсөв, ТЭЗҮ хийх зардлыг тусгах • Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдэх 	<p>Төвийн 2-р байр буюу Эмч нарын байрыг хөдөө орон нутгаас төгсөлтийн дараах сургалтад суралцахаар ирсэн эрүүл мэндийн ажилтны амьдрах дотуур байр, сургалтын танхим, анагаах ухааны номын сан, симулашон төв бүхий Эмнэлгийн мэргэжилтний хөгжил, мэдээлэл, сургалт, үйлдвэрлэл, ШУ, эрдэм шинжилгээ, судалгаа, техник, технологийн ордон шинээр барих танилцуулгыг:</p> <ul style="list-style-type: none"> • 2019 онд Эрүүл мэндийн сайд, ЭМЯ-ны СХОГ, Хот байгуулалт хөгжлийн газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, • 2020 онд Эрүүл мэндийн сайд, ЭМЯ-ны Хөрөнгө оруулалтын хэлтэс, • 2021, 2022 онд Эрүүл мэндийн сайд, • 2023 онд Эрүүл мэндийн сайд, ЭМЯ-ны СХОГ-т удаа дараа хүсэлтээ хүргүүлсэн. <p>Улмаар уг барилгыг нураах болон ТЭЗҮ боловсруулах зардал 2024 оны ЭМ-ийн сайдын багцын хөрөнгө оруулалтын төсөвт тусгагдаад байна.</p> <p>Байрыг буулгаж шинэчлэн барих ажлын хэсэг байгуулах Эрүүл мэндийн сайдын тушаалын төсөл боловсруулан СЭЗГ-ын дарга дээр хянагдаж байна.</p>